



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

**Барилга байгууламжийг нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 29 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба (хуучнаар Замын цагдаагийн газар)-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Худалдах доод үнийг 17,326,000,000.0 (Арван долоон тэрбум гурван зуун хорин зургаан сая) төгрөг дээр үнэлгээний ажлын зардал 7,000,000.0 (Долоон сая) төгрөгийг нэмж, 17,333,000,000.0 (Арван долоон тэрбум гурван зуун гучин гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

3. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, явуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Нээлттэй дуудлагын худалдааны ялагчтай Худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

5. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 барилга байгууламжийн нээлттэй дуудлагын худалдааны дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувь буюу 1,733,300,000.0 (Нэг тэрбум долоон зуун гучин гурван сая гурван зуун мянган) төгрөгөөр, үнэ өсгөх доод шатлалыг 10,000,000.0 (арван сая) төгрөгөөр тогтоож, нийтэд зарлахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

6. Шинэ өмчлөгчид шилжих хүртэлх хугацаанд өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг Итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Эрэвгийлхам, Ц.Шинэхүү, Тээврийн цагдаагийн алба (Д.Амарсайхан)-нд тус тус үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга А.Дагвадоржид даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТУВШИНЗАЯА